



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн банкны Баян-Өлгий аймаг дахь салбарын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 45,619,218.00 (дөчин таван сая зургаан зуун арван есөн мянга хоёр зуун арван найман) төгрөгийн балансын үнэ, 38,761,352.00 (гучин найман сая долоон зуун жаран нэгэн мянга гурван зуун тавин хоёр) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Төрийн банкны Баян-Өлгий аймаг дахь салбарын захирал Х.Жанузахад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу байгууллагадаа төвлөрүүлэх;


2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийн дүнг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

D:\Huraldaanii material\2018.03.06\togtool\04docx

0001499

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн  
5.2. дугаар тогтоолын хавсралт



Баян-Өлгий аймаг дахь Төрийн банкны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй  
дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон огноо	Явсан км	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)
1	Тоёото прадо 00-81 БӨА, арал № GX110- 60211E3	2008/ 2011	556,0	26,819,218.00	25,918,629.00	900,589.00	0	1,000,000.00	250,000.00
2	УАЗ-31514, 15- 96 БӨТ, арал № V70004533	2007/ 2007	326,0	18,800,000.00	12,842,723.00	5,957,277.00	0	6,000,000.00	1,500,000.00
	Нийт дүн			45,619,218.00 (дөчин таван сая зургаан зуун арван есөн мянга хоёр зуун арван найман)	38,761,352.00 (гучин найман сая долоон зуун жаран нэгэн мянга гурван зуун тавин хоёр)	6,857,866.00 (зургаан сая найман зуун тавин долоон мянга найман зуун жаран зургаан)		7,000,000.00 (долоон сая)	1,750,000.00